



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН
ҮНЭЛГЭЭ**

2023 он

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг гүйцэтгэсэн:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Х.Буянбат

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

Б.Сүнжидмаа

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	Error! Bookmark not defined.
УДИРТГАЛ.....	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	7
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	7
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	8
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	11
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	15
3.1. Цэцийн гишүүний томилгоо /МУҮХЦтХ-ийн 3-р зүйл/	15
3.1.1. Зорилгод хүрсэн түвшин	15
3.1.2. Практикт нийцэж байгаа байдал	18
3.2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага /МУҮХЦтХ-ийн 4-р зүйл/	19
3.2.1. Зорилгод хүрсэн түвшин	19
3.2.2. Практикт нийцэж байгаа байдал	20
3.3. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх /МУҮХЦтХ-ийн 5-р зүйл/	23
3.3.1. Зорилгод хүрсэн түвшин	23
3.3.2. Практикт нийцэж байгаа байдал	27
3.4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/ МУҮХЦтХ-ийн 6-р зүйл/	28
3.4.1. Зорилгод хүрсэн түвшин	28
3.4.2. Практикт нийцэж байгаа байдал	29
3.5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл /МУҮХЦтХ-ийн 7-р зүйл/	30
3.5.1. Зорилгод хүрсэн түвшин	30
3.5.2. Практикт нийцэж байгаа байдал	35
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	39
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ	41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
МУҮндХ	Монгол Улсын Үндсэн хууль
МУҮХЦтХ	Монгол Улсын Үндсэх хуулийн цэцийн тухай хууль
ҮХЦтХ	Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
УБ	Улаанбаатар

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 23 зүйлтэй анх баталснаас хойш өнгөрсөн 31 жилийн хугацаанд нийт 11 удаа /1995, 1997, 1999, 2003, 2016, 2005, 2020, 2021, 2022 онд/ нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 12 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн байна. Үүний хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 онд хийсэн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгаа хийснээс хойш хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийгдээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” хэсгийн 4.4.2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгажээ.

Мөн түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасанчлан Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай.

Иймд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох үүднээс Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх хэрэгцээ шаардлагатай гэж үзлээ.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр 23 зүйлтэй батлагдсанаас хойш өдийг хүртэл 11 удаа /1995, 1997, 1999, 2003, 2016, 2005, 2020, 2021, 2022 онд/ нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 12 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Тус хуулийн хэрэгжиж буй 31 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, төр, нийгэм, эдийн засгийн харилцаа ихээхэн шинэчлэгдэж, өөрчлөгдсөн байх бөгөөд энэ хугацаан дахь Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг энэ хууль хэрхэн зохицуулж байгааг үнэлж цаашид өөрчлөн сайжруулах үндэслэл шаардлага бий эсэхийг судалж тогтоох нь зүйн хэрэг билээ.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого гэсэн дөрөв дэх бүлгийн “Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл” хэсгийн 4.4.2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгажээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасанчлан Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн байна. Үүний хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 онд хийсэн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгаа хийснээс хойш хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийгдээгүй байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтоох ба тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг аль болох агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

1. Цэцийн гишүүний томилгоотой холбоотой зохицуулсан тус хуулийн 3-р зүйл;
2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус хуулийн 4-р зүйл;
3. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан тус хуулийн 5-р зүйл;
4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээний тухай зохицуулсан тус хуулийн 6-р зүйл;
5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай заасан тус хуулийн 7-р зүйл;
6. Цэцийн чиг үүрэг, эрх хэмжээ буюу маргаан хянан шийдвэрлэх эрх хэмжээг тогтоосон тус хуулийн 8, 9, 10, 12, 22-р зүйл.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаандаа анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно. Үндсэн зорилгыг тодорхойлохдоо МУҮндХ-ийн 64-өөс 67 дугаар зүйл, болон Цэцийн тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд заасныг баримтална.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/тохиолдол судлах.

Дээрхээс “байх ёстой ба одоо байгаа” болон “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн болон үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага зэрэгт харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт		Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод хүрсэн түвшин	Практикт нийцэж байгаа байдал		
Цэцийн гишүүний томилгоо /МУҮХЦтХ-ийн 3-р зүйл/	Цэцийн гишүүний томилгоо нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус	Цэцийн гишүүний томилгооны тухай зохицуулсан тус 3-р зүйл нь хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болоод	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦтХ-ийн 3-р зүйлээр зохицуулж буй Цэцийн гишүүний томилгоо нь Монгол Улсын	1. Цэцийн гишүүнийг томилох тухай зохицуулсан тус хуулийн зохицуулалт нь түүнийг хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавихад

	байна." гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу тус томилгоо нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх, мөн тус зүйлийн 3-"Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана." гэж заасанчлан Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл нь хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэхийг тогтооно.	хэрэгжилтэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай салбарын судлаачид хэрхэн үзэж буй талаар судалж тогтооно.	Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ "Тохиолдол судлах" харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.	нөлөөлж байгаа эсэх. 2. Тус хуулийн зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.
Цэцийн гишүүнд тавигдах шаардлага /МУҮХЦТХ-ийн 4-р зүйл/	Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн." гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэцийн гишүүн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байх, Мөн тус зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна." гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь	Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус 4-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болон хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ.	"Байх ёстой ба одоо байгаа" харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 4-р зүйлээр зохицуулж буй Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ "Тохиолдол судлах" харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.	1. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байхад чиглэгдсэн эсэх. 2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.

	цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.			
Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх/МУҮХЦТХ-ийн 5-р зүйл/	МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна." гэж тусгасан байдаг. Цэцийн гишүүний бие даасан байдал нь түүний бүрэн эрхийн баталгаагаар илэрнэ. Иймд тус хуулийн 5-р зүйл цэцийн гишүүний хараат бус, бие даасан байдлыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.	Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулсан тус 5-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт сөрөг үр дагавар гарч байгаа эсэх, хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ. Тодруулбал, Цэцийн гишүүний бүрэн эрхийн байдал практикт хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, эерэг болон сөрөг үр дагавар, хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдлыг судална.	"Байх ёстой ба одоо байгаа" харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 5-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ "Тохиолдол судлах" харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.	1. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулалт нь Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.
Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/МУҮХЦТХ-ийн 6-р зүйл/	МУҮндХ-ийн 65-р зүйлийн 3-т "Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно." гэж, мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2.1-т "Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол улсын Үндсэн хуульд нийцэх хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж тусгасан байдаг. Иймд цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа бие	Цэцийн дарга, түүний эрх хэмжээний талаар зохицуулсан тус 6-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгааг авч үзэх буюу Цэцийн дарга эрх хэмжээг хуулиар оновчтой зохицуулсан эсэх, практикт ямар үр дагаврыг гарч байгаа талаар судалж үнэлэлт өгнө.	"Байх ёстой ба одоо байгаа" харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 6-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ "Тохиолдол судлах" харьцуулах	1. Цэцийн даргын эрх хэмжээ нь Үндсэн хуулийн цэцийн хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэж буй эсэх. 2. Цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж

	даасан, хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж чадаж байгаа эсэхийг судална.		хэлбэрийг мөн ашиглана.	чадаж байгаа эсэх.
Цэцийн үйл ажиллагааны нөхцөл /МУҮХЦТХ-ийн 7-р зүйл/	Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай зохицуулалт нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэц энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх, тийнхүү зохицуулахдаа МУҮндХ-ийн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.	Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон тус зүйлийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр МУҮХЦТХ-ийн 7-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага, түвшинд хүрч, нийцэж байгаа эсэхийг судлах бөгөөд ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах	1. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх. 2. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэхдээ түүний хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, тус ажиллагааг

хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, тус ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

Тус судалгаанд ашигласан эх сурвалжийг жагсаавал:

Сурах бичиг, гарын авлага:

- Г.Совд “Шүүх , шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудал”, Монголын төр, эрх зүй, Дугаар 02, УБ,1997.
- Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2000.
- Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл /"Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол-практикийн бага хурал,УБ,2001.
- Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, 2007.
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008.
- Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй (хоёр дахь хэвлэл), УБ 2021
- О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” Эрх зүй 36, Дугаар 4 (2016).
- Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, МУИС пресс, 2016.
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, УБ, 2021.
- Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, УБ, 2023.
- ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, 2023.

Хууль, эрх зүйн акт:

- Үндсэн хууль, (1992);
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992);
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997);
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 05 өдрийн 78 дугаар тогтоол гэх мэт.

Судалгааны тайлан эмхэтгэл:

- ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, (УБ, 2023);

- Н.Отгончимэг "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа" (УБ, 2021);
- ХЗҮХ, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ" судалгааны тайлан. (УБ, 2018);
- ХЗҮХ, "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, (УБ, 2016) гэх мэт.

Олон улсын гэрээ, конвенци:

- Venice Commission Report; гэх мэт.

Цахим эх сурвалж

1. Арне Мавчич, *Үндсэн хуулийн хяналт* (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 40-42 дахь тал. <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/> Сүүлд үзсэн огноо: 2018.12.24.
2. "Д.Сугар ба Цалингийн 30 Хувь", news.mn
3. <https://www.courts.ca.gov/5367.htm>, 2023.11.16
4. <https://equur.mn/415949/>, 2023.11.13

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Цэцийн гишүүний томилгоо /МУҮХЦтХ-ийн 3-р зүйл/

3 дугаар зүйл. Цэцийг байгуулах журам

- 1.Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Цэцийн гишүүнийг **нэг удаа улируулан томилж болно.**
2. Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо Улсын Их Хурлын дарга зохих байнгын хороодын санал дүгнэлтийг үндэслэн захирамж, Ерөнхийлөгч захирамж, Улсын Дээд шүүх гишүүдийнхээ олонхийн саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана.
3. Санал болгосон хүнийг Улсын Их Хурал Цэцийн гишүүнээр томилохоос татгалзсан бол санал оруулсан байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар өөр хүний нэр дэвшүүлнэ.
4. Цэцийн гишүүнийг нөхөн томилохдоо орон гарсан гишүүнийг урьд томилох санал болгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналаа арван дөрвөн хоногийн дотор гаргах бөгөөд түүнийг Улсын Их Хурал гуч хоногийн дотор шийдвэрлэнэ.
5. Цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно. Цэцийн гишүүн Засаг захиргаа, нам-улс төрийн болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж, үйлдвэрчний эвлэлийн удирдах ажил хийж болохгүй.
6. Цэцийн гишүүн Улсын Их Хурлын гишүүнд буюу Монгол Улсын Ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлбэл тухайн сонгуулийн дүн гартал Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ.
7. Цэцийн гишүүн Цэцээр хянан шийдвэрлэх маргаантай асуудал болон Цэцийн хянаж байгаа маргааны талаар Цэцийн шийдвэр гараагүй байхад өөрийн санал, дүгнэлтийг олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цэцийн хуралдааны явцад ямар нэгэн хэлбэрээр урьдчилан илэрхийлэхийг хориглоно.

3.1.1. Зорилгод хүрсэн түвшин

Цэцийн гишүүний томилгоо нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу тус томилгоо нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх, мөн тус зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасанчлан Цэцийн тухай хуулийн холбогдох зүйл нь хараат бус байдлын баталгааг хангаж чадаж буй эсэхийг энэ хэсэгт тогтооно.

Цэцийн гишүүнийг томилохтой холбоотой зохицуулалтыг Цэцийн тухай хуульд хуульчлан зохицуулсан зорилго нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох процессыг нарийвчлан зохицуулахад оршино. Өөрөөр хэлбэл, цэцийн гишүүнийг томилохтой холбоотой бүхий л харилцааг тодорхой хуульчлан зохицуулах нь Үндсэн хуулийн цэцийн хараат бусаар Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болно.

Цэцийн гишүүнийг хэзээ санал болгох нь тодорхой бус. Цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-т “Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Цэцийн

гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.” гэж заасан нь цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг тодорхойлсон заалт юм. Цэцийн гишүүн нь энд заасан 6 жилийн хугацаанд л бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэсэн үг.

Гэвч уг заалтад тухайн санал болгох эрх бүхий байгууллагуудаас Цэцийн гишүүнд хэзээ санал болгох нь тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл, Цэцийн гишүүдээс хэн нэгнийх нь хугацаа дуусгавар болсон тохиолдолд түүний оронд шинэ Цэцийн гишүүнийг хэдий хугацаанд томилох тухай зохицуулалт тус зүйл болоод тус хуульд огт заагаагүй. Энэ нь хуулийн дагуу бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Цэцийн гишүүн бүрэн эрхээ тодорхойгүй хугацаагаар хэрэгжүүлсээр байх нөхцөлийг үүсгэсэн байна.

Харин 2021 онд шинэчлэн найруулж батлагдсан Шүүхийн тухай хуулийн 25.8.7-д “Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах” гэж зааснаар тус асуудлыг шүүхийн институтын хувьд шийдвэрлэсэн байна. Хэдийгээр ийнхүү тодорхой зохицуулсан нь зөв зүйтэй хэрэг ч бусад институтээр ийнхүү зохицуулаагүй байгаа нь эрх мэдэл хоорондын тэнцвэрийг хангах, Цэцийн хараат бус байдлыг хангахад сөрөг үр дагавар учруулж болох эрсдэлтэй байна.

Иймд Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дуусгавар болсноос хойш тодорхой хугацааны дотор Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ээс тухайн гишүүний орны гишүүнийг санал болгох талаар нэг мөр хуульчлах шаардлагатай.

Цэцийн гишүүнийг УИХ томилох процедур тодорхой бус. Цэцийн гишүүнийг УИХ-аас томилдог. Гэвч одоогоор тус томилгоо хэрхэн явагдах тухай Цэцийн тухай хуульд огт заагаагүй буюу зохицуулсан хэсэг нь хэрэгжих боломжгүй байна.

Доктор, профессор Н.Лүндэндорж МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Үндсэн хуулийг чандлан сахиулж, дээд хяналтыг хэрэгжүүлэх субъектийг тодруул томилоход төрийн эрх мэдлийн аль нэг салааны нөлөөг дангаар бий болгохгүйн үүднээс гурван өөр байгууллагад санал болгох буюу олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулалт явуулан нэр дэвшүүлэх үндсэн дээр нэгэн бүрэн эрхийн хугацаанд зургаан жилийн хугацаанд УИХ томилох”¹ хэмээн тайлбарласан байна. Энд томилгоонд олон нийтийн оролцоог хангах ёстой тухай өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, Цэцийн гишүүнд санал болгож буй нэр дэвшигч нь Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэх, хэрхэн хангаж буй талаар олон нийт мэдэх, нягтлах шаардлагатай юм. Энэхүү үндэслэлээр 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар тус 3-р зүйлийн 1-дэх хэсэгт “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмэлт оруулсан. Ингэснээр Цэцийн гишүүнийг томилоход УИХ-д нээлттэй сонсгол хийх болсон. Гэвч Үндсэн хуулийн цэц уг залтыг Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна” гэх заалтыг зөрчсөн хэмээн үзэж 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтээр 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн

¹ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, УБ, 2022, 977 дахь тал.

түдгэлзүүлсэн. Ингэснээр Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх процесс ахин хаалттай хэлбэр рүү ороод буй юм.

АНУ-д Дээд шүүхийн шүүгчийг нэр дэвшүүлэхдээ нээлттэй сонсгол явуулдаг ба ингэснээр нэр дэвшигч нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг нягтлах, шударга² шүүлт хийхэд дэмжлэг үзүүлдэг. Доктор О.Мөнхсайхан Цэцийн гишүүнд томилогдож байгаа нэр дэвшигчид шаардлага хангасан эсэх нь эргэлзээтэй хэд хэдэн хүмүүс сонгогдож ажиллаж байсан талаар онцолж “нээлттэй сонсголоор цэцийн гишүүнд нэр дэвшигч дээр үндсэн хуулийн мэдлэг, хууль тайлбарлах ур чадвар, туршлага, ёс зүй болоод үнэт зүйл дээр нь мэргэжлийн дүгнэлт гаргах эсхүл нэр дэвшигч өмнө нь ноцтой ёс зүйн зөрчил гаргаж байсан тухай мэддэг хүнээр үг хэлүүлэх боломжтой. Мөн нээлттэй сонсголын үеэр УИХ-ын эрх бүхий гишүүд эргэлзээгээ тайлах хүртлээ асуулт асууж болно³.” гэх байр суурийг илэрхийлсэн байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход нэр дэвшигчийн сонсгол хийх зохицуулалт нь нэр дэвшигчийг уг албан тушаалд тэнцэх эсэхийг шалгаж баталгаажуулахад чухал ач холбогдолтой байна.

Нэгэнтээ Цэцийн тухай хуулиар тодорхой заагаагүй учир бусад хуулиар зохицуулахаас өөр замгүй. Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.1-т УИХ Цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо ажлын 5 өдрийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.” гэж заасан нь дээр дурдсан Нийтийн сонсголыг зохион байгуулсан ч олон нийт оролцох буюу мэдэх, нягтлах боломжоор хангагдаж амжихааргүй богино хугацаа юм. Иймд Цэцийн гишүүнийг УИХ томилох процедурыг Цэцийн тухай хуулиар тодорхой зохицуулах нь зүйтэй.

Цэцийн гишүүнийг улируулан томилох тухай зохицуулсан нь МУҮндХ-д нийцсэн эсэх нь тодорхой бус. МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасан бол Цэцийн тухай хуульд Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болохоор заасан байсан. Тус хэсгийн “Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно” гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон нь өдгөө хэдэн ч удаа Цэцийн гишүүнээр улиран томилогдож болох нөхцөлийг үүсгээд байна.

Судлаачид МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг харилцан адилгүй тайлбарладаг. Доктор, профессор Н.Лүндэндорж уг заалтыг “Цэцийн гишүүнээр 1 удаа, 6 жилийн хугацаагаар томилогдоно”⁴ гэж тайлбарласан бол Г.Совд, Н.Жанцан нар “Үндсэн хуулийн Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нэг удаагийн томилолтоор хязгаарлагддаггүй”⁵ гэж тайлбарласан байна.

Үндсэн хуулийн хяналт сайн хөгжсөн гадаадын зарим орны жишээг харвал, ихэнхдээ шүүгчийг улируулан томилохыг хязгаарласан байдаг. Учир нь Цэцийн гишүүн

² <https://www.courts.ca.gov/5367.htm>, 2023.11.16

³ О.Мөнхсайхан. Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь, 18-20 талд.

⁴ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, УБ 2022, 977 дахь тал.

⁵ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ 2000 он, 255 дахь тал.

улиран томилогдохын тулд өөрийг нь нэр дэвшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны ашиг сонирхлын дагуу шийдвэр гаргах магадлалтай тул “улиран томилогдох” талаар хязгаарлалт тавьж гишүүний бие даасан, хараат бус байдлыг хангадаг. Тодруулбал, улиран томилогдох боломжийг хуулиар олгох явдал нь шүүгчийн хараат бус байдалд харшилна.⁶

1992 оны Үндсэн хуулийг боловсруулах явцад Цэцийн гишүүнийг улируулан томилохыг хориглох заалт оруулах талаар гадны эрдэмтдийн дүгнэлт гарч байсан боловч улируулан томилох асуудлыг илэрхий хориглосон заалт ороогүй учир өдийг хүртэл дахин томилогдсоор иржээ. 1992-2021 оны хооронд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдон ажиллаж байснаас дөрвөн удаа улиран ажилласан 1 гишүүн, гурван удаа ажилласан 1 гишүүн, хоёр удаа улиран ажилласан 4 гишүүн байна.

Хүн ам цөөнтэй манай улсын хувьд Цэцийн гишүүнийн бүрэн эрхт хугацааг 6 жилээр тогтоон нэг удаа томилох тохиолдолд шалгуур хангасан хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Тиймээс Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулбал хүний нөөцийн хомсдолоос сэргийлэхийн зэрэгцээ цэцийн гишүүний хараат бус байдлыг баталгаажуулах боломжтой⁷ хэмээн судлаачид санал нийлдэг.

3.1.2. Практикт нийцэж байгаа байдал

Энэхүү дэд хэсэгт Цэцийн гишүүний томилгооны тухай зохицуулсан тус 3-р зүйл нь хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болоод хэрэгжилтэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай салбарын судлаачид хэрхэн үзэж буй талаар судалж тогтооно.

Цэцийн гишүүнийг хэзээ санал болгох нь тодорхой бус байгаагаас үүдэж УИХ, Ерөнхийлөгч, УДШ-ээс нэр дэвшүүлэх санал гаргахгүй удаж Цэцийн гишүүн бүрэн эрхээ 6 жилээс урт хугацаагаар хэрэгжүүлэх нөхцөл үүссэн. Үүний нэг жишээ нь Цэцийн гишүүн асан Н.Жанцан нь Ерөнхийлөгчөөс дөрвөн удаа санал болгосны дагуу 1992 оны 7 сарын 1-нээс эхлэн томилогдсон тул 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 24 жил ажилласан байх ёстой. Гэвч тэрээр 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хүртэл Цэцийн гишүүнээр 26 жил ажиллажээ. Өөрөөр хэлбэл, түүний бүрэн эрхийн хугацаа даруй 2 жилээр хэтэрсэн юм. Мөн УДШ-ээс нэр дэвшүүлэх санал гаргах хугацааны зохицуулалт байхгүй үед Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш 2 жил хүртэл санал болгодоггүй тохиолдол гарч байсан.

Цэцийн гишүүнийг УИХ томилох процедур тодорхой бус буюу УИХ-д томилох ажиллагааны хугацааны зохицуулалт хэт богино байгаагаас үүдэн Цэцийн гишүүний талаар олон нийт болоод УИХ хангалттай мэдээлэл авч чаддаггүй. Үүний жишээ нь УИХ-ын 2018 оны 33 дугаар тогтоолын хүрээнд УИХ-ын даргын 2018.05.21-нд 107 тоот захирамж гарган Цэцийн гишүүнд Ш.Солонгыг нэр дэвшүүлсэн бөгөөд 2018.05.22-нд Төрийн байгуулалтын байнгын хороо, 2018.05.23-нд Хууль зүйн байнгын хороо тус тус

⁶ Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, УБ, 2021, 73-74 дэх тал.

⁷ О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, Эрх зүй сэтгүүл цуврал 36, УБ, 2016, 12-16 дахь тал.

хэлэлцэж дэмжээд, 2018.05.24-ний 12:11 цагт баталсан 33 дугаар тогтоолоор томилжээ.⁸ Мөн тухайн үед Ерөнхийлөгчөөс Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж, Г.Туулхүү нарыг Цэцийн гишүүнд санал болгох тухай зарлигийг 2018.05.18-нд гаргасан боловч тус нэр дэвшигчдийн тухай мэдээлэл нийтэд 3 өдрийн дараа ил болж Хууль зүйн байнгын хороо 2018.05.23-нд хэлэлцэн дэмжиж 2018.05.24-ний өдөр УИХ-ын 35 дугаар тогтоолоор томилогдсон. Эдгээр тохиолдлуудад 3 өдрийн дотор Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлж, томилсон байгаа нь олон нийтэд тэдний Цэцийн гишүүний шаардлагыг хангаж буй эсэх талаар мэдээлэл авах, хэлэлцэх боломж гараагүй нь харагдаж байна.

Цэцийн тухай хуульд Цэцийн гишүүнийг улируулан томилох тухай зохицуулсан нь МУҮндХ-д нийцсэн эсэх нь тодорхой бус байдлаас үүдэж тус асуудал практикт үргэлж маргаан дагуулсаар ирсэн. Гэсэн хэдий ч 1992-оос 2021 оны хооронд Цэцийн гишүүнээр нийт 37 хүн томилогдсоноос нэг гишүүн 4 удаа, нэг гишүүн 3 удаа, дөрвөн гишүүн 2 удаа тус тус дахин томилогдсон байна.⁹

3.2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлага /МУҮХЦТХ-ийн 4-р зүйл/

4 дүгээр зүйл.Цэцийн гишүүн

- 1.Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.
- 2.Цэцийн бүрэлдэхүүнд шинээр буюу нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхэлж, бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ.
- 3.Цэцийн гишүүний бүрэн эрх нь Улсын Их Хурлаас дараагийн гишүүнийг томилсноор дуусгавар болно.
- 4.Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу Цэцийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдөж болно

3.2.1. Зорилгод хүрсэн түвшин

Энэ дэд хэсэгт Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэцийн гишүүн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх мэдлэг чадвар бүхий байх, Мөн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэх буюу Цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.” гэж заасныг Цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-т “Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.” гэж эрүүгийн ял шийтгэлгүй байх болон Цэцийн гишүүд эрх тэгш байх тухай 2 шаардлагыг нэмж

⁸ Хүний эрх Дэвшилтэт бодлогын хүрээлэн, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” тойм судалгаа, УБ, 2021, 418 дахь тал.

⁹ Мөн тэнд, 419 дэх тал.

хуульчилжээ. Харин хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байх тухайд ямар ч нэмэлт агуулгагүй заасан байна.

Венецийн комиссын “CDL-STD (1997) 020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн-Шинжлэх ухаан болон Ардчиллын техник” тайланд үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагын тухайд “Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлагад шүүхийн чадварлаг бүрэлдэхүүнийг хангахын тулд хууль зүйн мэргэшлийн шаардлагыг ихэнх тохиолдолд тусгадаг.”¹⁰ хэмээн өгүүлжээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэсэн “Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”-нд дурдсанаар сонгон судалсан ХБНГУ, Австри, ОХУ, БНСУ, Латви улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь мэргэжлийн хувьд эрх зүйн дээд боловсролтой байх шаардлага тавигддаг байх бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг зөвхөн Австри улс Үндсэн хуульдаа, бусад улс нь органик хуульдаа тусгаж зохицуулжээ.¹¹ Эндээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах эрх зүйн дээд боловсрол, хууль зүйн мэргэшлийн шаардлага нь заавал тавих шаардлагатай болох нь харагдаж байна.

Венецийн комиссын Үндсэн хуулийн эрх зүй, эрх зүйн мэдээллийн тогтолцоо хариуцсан мэргэжилтэн, доктор Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт” номдоо “Бараг бүх улсад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавих шаардлага, ажил мэргэжлийн туршлагын шалгуур өндөр байна. Нэр дэвшигчид зөвхөн эрх зүйн боловсролыг дунджаас дээш түвшинд эзэмшсэн байхаас гадна өөрсдийн шийдвэрийнхээ улс төрийн ач холбогдлыг сайн мэдэрдэг байх шаардлагатай.”¹² хэмээн үндсэн хуулийн шүүгч улс төрийн мэдлэгтэй байх чухлыг онцолсон ч эрх зүйн боловсролыг дунджаас дээш түвшинд эзэмшсэн байх нь суурь шаардлага болохыг дурджээ.

Иймд Цэцийн тухай хууль органик хууль болохын хувьд МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-ыг дэлгэрүүлэн Цэцийн гишүүн эрх зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэшлийн шаардлагыг хангасан байхыг тухайлан заах шаардлагатай байна.

3.2.2. Практикт нийцэж байгаа байдал

Энэхүү дэд хэсэгт Цэцийн гишүүнд тавигдах шаардлагын тухай зохицуулсан тус 4-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх болон хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Монгол Улсын төрийн түүхэнд урьд нь байгаагүй 1992 оны Үндсэн хуулиар байгуулагдсан шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд ажиллах үүрэгтэйгээр төрийн тогтолцоонд буй болсон цоо шинэ байгууллага юм. Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн, биш гэх маргаан нийгэмд хөнддөг. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны шалгуурыг авч үзвэл: Үндсэн хуулийн цэц нь

¹⁰ Венецийн комисс, Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, орчуулж эрхлэн гаргасан МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, УБ 2023, 22 дахь тал.

¹¹ Н.Отгончимэг, Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа, УБ 2019, 37 дахь тал.

¹² Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт, УБ 2014, 43 дахь тал.

Үндсэн хуулийн биелэлтэд хууль-шүүхийн дээд хяналт тавьдаг; энэ үүргээ байцаан шийтгэх ажиллагааны зарчим, журам, арга явцаар хэрэгжүүлдэг; Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянаад хууль хэрэглэж эцэслэн шийдвэр гаргадаг; шийдвэр гармагц Үндсэн хуулийн ёсоор хүчин төгөлдөр болдог; түүнийг холбодог байгууллага, албан тушаалтан хэн боловч заавал биелүүлнэ; ҮХЦ, түүний гишүүн нь гагцхүү Үндсэн хуульд захирагдах, аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байх Үндсэн хуулийн зарчим баримтална. Эдгээр шалгуур нь ҮХЦ-ийг шүүх мөнийг нотолдог. Үүнээс харахад Үндсэн хуулийн цэц нь шүүх мөн бол Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлага нь шүүгчийн хэмжээнд байх ёстой.

Үндсэн хууль тогтоогчид Цэцэд хэн нэр дэвшиж болох вэ гэдэг дээр өргөн болон явцуу хоёр янзын үзэл баримтлалыг барьж байсан. Өргөн үзэл баримтлалын дагуу хуульч, улс төрч, дипломат, улс төр судлаач, эдийн засагч зэрэг өөр өөр мэргэжлийн хүмүүс Цэцэд нэр дэвших боломжтой гэж үзэж байсан. Үндсэн хуулийн маргаан бол эрүүгийн хууль зөрчсөнтэй адилхан маргаан биш, "... Үндсэн хууль гэдэг маань нийгмийн бүх амьдралыг хамарсан өргөн хүрээний асуудал шийддэг учраас хуульчаас гадна улс төрч, эдийн засагч байх шаардлага гарч болно." гэж үзсэн. Үндсэн хууль тогтоогчдын зарим нь энэхүү өргөн үзэл баримтлалыг няцааж, зөвхөн хуульчид Цэцэд нэр дэвших эрхтэй байх ёстой гэсэн явцуу үзэл баримтлалыг дэмжиж удаан хэлэлцсэний эцэст Цэцийн гишүүд нэр дэвшигчид тавигдах шаардлагын талаар ерөнхий заалтыг Үндсэн хуульд оруулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно." гэж заасан байдаг ба энэхүү заалт дах хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэх ойлголтыг практикт аль нь ч байж болох мэтээр ойлгодог жишиг тогтсон.

"Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй" гэдэг нь "хууль зүй, улс төр" гэсэн хоёр ойлголтын хооронд таслал байгаа тул "эрх зүйч" эсвэл "улс төр судлаач" байж болох нь гэж ойлгож болохгүй. Үндсэн хуулийн шүүх нь Морис Дювержийн шуудхан хэлснээр бүрэлдэхүүнийг томилох ажиллагаа нь улс төрийн дээд институтын оролцоо, зөвшилцлийг агуулдаг, улс төрийн арга хэрэгслийг ашиглан томилдог, шийдвэр нь Үндсэн хуулийн мөн чанараас хамаарч улс төрийн шинжийг зүй ёсоор агуулдаг, улс төрийн үр дагавар үүсгэдэг нь нууц биш учраас Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь шийдвэрийнхээ улс төрийн үр дагаврыг мэдрэх, мэдэх шаардлага зүй ёсоор тулгарна. Үүнээс хамаарч эрх зүйч мэргэжлийн тодорхой чиглэлээр мэргэших байх, ялангуяа Үндсэн хуулийн эрх зүйн маргаан шийдвэрлэх учраас хууль зүй, улс төрийн хосолмол судлагдахуунтай Үндсэн хуулийн эрх зүйгээр академик болон академик бус хүрээнд мэдлэг, чадвар, туршлага, дадал дүйгээ нарийсган, гүнзгийрүүлж, ердийн төвшнөөс дээгүүр, бүрнээ бэлтгэгдсэн байх шаардлага зүй ёсоор тавигдана.

Шүүгч хүн улс төрийн албан тушаалтан биш, шүүх нь улс төрийн хүчнүүдийн төлөөллийн нэгж буюу улс төрийн харилцааг тэнцүүлэх зориулалтаар баримтлан хуулийн ноёрхлыг тогтоож үндсэн эрхийг хамгаалах зориулалттай байгууллага байдаг. Ийм ч учраас шүүгч хүн, энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн гишүүн хүн мэргэжлийн арвин туршлагатай хуульч хүн байх ёстой юм. Цэцийн гишүүний үндсэн мэргэжил нь хуульч байх ёстой нь ойлгомжтой ч зөвхөн хуульч мэргэжлээс гадна улс төрийн зохих боловсрол, дадлага давхар эзэмшсэн байх шаардлагатай.

Монгол Улсад хуульч биш төдийгүй эрх зүйч биш хүмүүс Цэцийн гишүүнээр томилогдож ирсэн. 1992-оос 2021 оны хооронд Цэцийн гишүүнээр томилогдсон 37 хүний 5 нь хуульч бөгөөд эрх зүйч биш байсан ба тэдгээрийн хоёр нь түүхч, хоёр нь геологич, нэг нь дипломатч мэргэжилтэй байжээ. Харин үлдсэн 32 хүн нь эрх зүйч мэргэжлээрээ бараг ажиллаагүй бөгөөд улс төрийн албан тушаал хашиж байв.¹³

Цэцийн хууль тогтоогчдоос бүрдсэн УБХ 1992 оны 5 сарын 8-ний Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн тухай хуулийг батлахдаа Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаар өргөн үзэл баримтлалыг баримталсан Цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн 65-р зүйлийн 2-т заасан "хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй" гэдэг шаардлагыг дэлгэрүүлэн тайлбарлаж тодорхойлоогүйгээс уг хууль үйлчилж эхэлснээс хойш Цэцийн гишүүн нь хуульч төдийгүй бусад мэргэжлийн хүн байхыг зөвшөөрч хууль зүйн салбарт мэргэшсэн бүү хэл хууль зүйн мэргэжлийн байх шаардлага тавьдаггүй практик нэгэнт тогтсон байна.

2012 онд Үндсэн хуулийн цэцэд нэр нэр бүхий иргэн мэдээлэл гаргаж, Цэцийн тухайн үеийн зарим гишүүн хууль зүйн мэргэшилгүй, иймд хуульд заасан шаардлага хангаагүй нэр дэвшигчийг томилсон УИХ-ын тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан үзэж шийдвэрлэж өгөхийг хүссэн байдаг. Тухайн үед Цэцийн тухай хууль болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хүрээнд, Цэцийн гишүүнд тавих шаардлагыг илүү нарийвчилж зохицуулахаар байсан тул маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж байжээ.¹⁴

Доктор, профессор Ц.Сарантуяа Үндсэн хуулийн процессын эрх зүй номынхоо хоёр дахь хэвлэлд "Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг бусад шүүгчид тавих хуульд заасан болзолтой уялдуулан 2015 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хууль зүйн мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг заахаар санал болгосон боловч тухайн төслийг УИХ эдүгээ хүртэл хэлэлцээгүй" хэмээн дурджээ.

¹³ Хүний эрх Дэвшилтэт бодлогын хүрээлэн, "Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл" тойм судалгаа, УБ, 2021, 420 дахь тал.

¹⁴ Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй (хоёр дахь хэвлэл), УБ 2021, 60 дахь тал.

3.3. Цэцийн гишүүний бүрэн эрх /МУҮХЦтХ-ийн 5-р зүйл/

5 дугаар зүйл. Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа

1. Цэцийн гишүүнийг Цэцийн зөвшөөрөлгүйгээр /түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд/ баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.
2. Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.
3. Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, ~~эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон~~ бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.
4. Цэцийн гишүүнийг хувийн хүсэлтээ гаргасан, эрүүл мэндийн улмаас, эсхүл Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө уг албан тушаалаас чөлөөлөх, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно.
5. Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан болон Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад үндэслэлээр Цэцийн гишүүнээс чөлөөлөгдвөл гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар хангана. Хэрэв тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж улсын төсвөөс мөн хугацаанд олгоно.
6. Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно.

3.3.1. Зорилгод хүрсэн түвшин

МУҮндХ-ийн 64-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж тусгасан байдаг. Цэцийн гишүүний бие даасан байдал нь түүний бүрэн эрхийн баталгаагаар илэрнэ. Иймд тус хуулийн 5-р зүйл цэцийн гишүүний хараат бус, бие даасан байдлыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

Монголын Үндсэн хуулийн 64.2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж тусгаж өгсөн байдаг. Мөн Цэцийн гишүүний хараат бус байдлыг хангах баталгаа нь хууль тогтоомж, цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа, нийгэм эдийн засгийн баталгаа зэрэгт оршдог. Гэвч эрдэмтэд, судлаачид цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа хангалтгүй, дутмаг байна гэж тодорхойлсон байна. Тухайлбал, 2018 оны ХЗҮХ-ийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт” хийсэн үнэлгээний тайланд Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангах асуудал зохицуулагдаагүй байна гэж үзсэн байна. Мөн доктор П.Очирбат “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал нь хууль зүй, нийгэм, эдийн засаг, үйл ажиллагааны бусад баталгаагаар хангагдсан байх ёстой ба Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал нь гишүүний хараат бус байдлын нэг чухал баталгаа болдог.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгааг хангах асуудал хараат бус байдалд чухал ач холбогдолтой бөгөөд энэ талаарх харилцааг зарим улсад тусгайлсан актаар зохицуулах хандлага давамгайлах болсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд ийм баталгаа байхгүй¹⁵ гэсэн байна. Тус зохицуулалт хуулийн зорилго болох хараат бус байдлыг хангаж өгөөгүй байна.

Гадаад улс, орнуудад цэцийн гишүүдийн бүрэн эрх, эдийн засгийн баталгааг дараах байдлаар хуульчилж өгсөн байна¹⁶.

Хүснэгт 1. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа зохицуулсан байдал

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа
Гүрж ¹⁷ Улс	"Үндсэн хуулийн шүүгчдийн нийгмийн баталгааны тухай хууль"	– Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээг хуулиар тогтоох бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн Дэд ерөнхийлөгч болон Нарийн бичгийн даргын сарын үндсэн цалин нь Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн цалингийн 90 хувиас багагүй, харин гишүүний цалин нь 85 хувиас багагүй байх; – Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн сарын нэмэгдэл цалин нь түүний цалингийн 90 хувиас багагүй, харин Дэд ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга, гишүүний нэмэгдэл цалин нь тэдгээрийн үндсэн цалингийн 50 хувиас багагүй байхаас гадна тэдгээрт ажилласан жил, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох; – Үндсэн хуулийн шүүхийн гишүүдэд жилд 45 хоногийн ээлжийн амралт эдлүүлэх бөгөөд амралт авахаас нь өмнө хоёр сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх; – Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч гадаад улсад албан айлчлал хийх нөхцөлд цалингийн 50, 40, 35 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт цалин олгох; – Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга, гишүүнийг тэтгэвэрт гарах үед авч байсан цалингийн 100 хувиар тэтгэвэр тогтоох; – Үндсэн хуулийн шүүхийн гишүүн болон гишүүн байсан хүн нас барсан эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд түүгээр тэжээн тэтгүүлж байсан түүний эхнэр, нөхөр болон 18 насанд хүрээгүй хүүхдэд тэтгэврийн хэмжээгээр тэтгэвэр олгох; – Үндсэн хуулийн шүүхийн гишүүн болон гишүүн байсан хүн нь албаны чиг үүрэгтэй холбоотойгоор бусдын халдлагад өртөн нас барсан тохиолдолд түүний эхнэр, нөхөр болон хүүхдэд түүний авч байсан цалин, эсхүл тэтгэврийн 10 жилтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг материаллаг бусад тусламж үзүүлснээс үл хамааран олгох;

¹⁵ П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа (УБ, 2017), Мөнхийн үсэг, 341 дэх тал.

¹⁶ Д. Наранчимэг "Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим", Н.Жанцан нар, "Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт(УБ, 2017)", Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 230-231 дэх тал.

¹⁷ мөн тэнд.

		– Үндсэн хуулийн шүүхийн гишүүн нь хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан тохиолдолд түүний 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлэхээс гадна гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний цалин, бусад хангамжийг бууруулахыг хориглосон байна.
Словени ¹⁸ Улс	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	– Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчтэй ижил хэмжээний цалин болон нэмэгдэл авах; – Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь Үндэсний Ассамблейн Дэд Ерөнхийлөгчтэй ижил хэмжээний цалин болон нэмэгдэл авах; – Үндсэн хуулийн шүүх Нарийн бичгийн даргын цалинг тогтоох бөгөөд цалингийн хэмжээ нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалинтай тэнцүү хэмжээтэй байх; – Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь ээлжийн амралтын хугацаанд, эрүүл мэндийн болон ослын шалтгаанаар чөлөө авсан хугацааны эхний 30 хоногт сарын цалингийн хэмжээтэй тэнцүү хэмжээний цалин авах; – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид ажилдаа ирэх, буцах унааны зардал, томилолтын зардал, үдийн хоолны зардал, ээлжийн амралтын мөнгө, нүүх зардал, ажлын байр нь байрладаг газраас байнга оршин суудаг газар руугаа ирж, буцах зардал, байнга оршин суудаг газраасаа ажлын байрны ойролцоо газар нүүх зардал, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал, удаан жилийн нэмэгдэл, тэтгэвэрт гарсны тэтгэмж зэрэг нөхөн олговор авах; – Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь жилд нэг удаа 40 хоногийн ээлжийн амралт, хувийн шалтгаанаар 7 хүртэл хоногийн цалинтай чөлөө авах; – Үндсэн хуулийн шүүгчээр сонгогдохоосоо өмнө аль нэг шатны шүүхэд, эсхүл төрийн аль нэг байгууллагад байнгын ажил, албан тушаал эрхэлж байсан бол бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш өмнөх ажлын байрны тодорхойлолтыг бүрэн хангаж байвал гурван сарын дотор тухайн байгууллагад өмнөх ажилдаа эргэн очих тухай мэдэгдэж, уг ажилдаа эргэн томилогдох; – Үндсэн хуулийн шүүгчээр сонгогдохоосоо өмнө аль нэг байгууллага, олон нийтийн компани, байгууллагад ажиллаж байсан бол бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор уг ажилдаа

¹⁸ Арне Мавчич, *Үндсэн хуулийн хяналт* (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 40–42 дахь тал. <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/> Сүүлд үзсэн огноо: 2018.12.24.

		эргэн томилогдох, эсхүл өөрийн боловсрол, мэргэжлийн түвшинд тохирсон ажил эрхлэх; – Бүрэн эрхийн хугацаа дууссан ч бодит шалтгааны улмаас өмнө хашиж байсан ажил албан тушаалыг эрхлэх боломжгүй болсон, эсхүл тохирох ажлын байраа олж чадаагүй байгаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй бол сарын цалингийн хэмжээтэй тэнцүү хэмжээний нөхөн олговрыг нэг жилийн хугацаанд авах эрхтэй байхаар зохицуулсан байна.
Беларусь 19 Улс	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	– Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон шүүгчдийн цалинг тус улсын Дээд зөвлөлийн дарга, нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга нартай ижил хэмжээнд тогтоосон байна. – Мөн орон байргүй, эсхүл нийтийн байранд амьдардаг зэрэг бусад шалтгаанаар амьдрах нөхцөлөө сайжруулах шаардлагатай шүүгчдэд томилогдсон даруй болон ийм шаардлага бий болсон үеэс хойш зургаан сарын хугацаанд багтааж улсын төсвийн хөрөнгөөр Минск хотод орон сууцаар хангах тухай Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд тусгажээ. – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа тэтгэвэрт гарах, эсхүл хуульд заасан бусад шалтгаанаар хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд шүүгчээр томилогдохоос өмнө эрхэлж байсан ажилдаа, энэ ажил нь үгүй болсон байвал ижил түвшний өөр ажилд томилогдох эрхтэй байхаар зохицуулсан байна. – Харин бүрэн эрхийн хугацаа дууссан болон тэтгэвэрт гарсан шүүгч нь хуульд заасны дагуу ердийн шүүхийн шүүгч нарын нэгэн адил баталгаагаар хангагдахаар байна.
Оросын Холбооны 20 Улс	“Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах, шүүгчдэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд төрийн болон	– ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарт зэрэг, цолны нэмэгдлээс гадна гадаад хэлний мэдлэгээ албаны үүргээ хэрэгжүүлэхдээ ашигласны төлөө сар бүрийн цалин дээр мөнгөн шагнал болгон нэмэгдэл олгох, – ОХУ-ын нутаг дэвсгэрийн хүрээнд төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгсэл, таксинаас бусад хот хоорондын тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих, орон сууц, албаны унаа, харилцаа холбооны хэрэгслээр хангагдах, орон сууцны төлбөрийн болон орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийг төрөөс хариуцах,

¹⁹ Арне Мавич, Үндсэн хуулийн хяналт (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 39 дэх тал.

²⁰ Д.Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт (УБ, 2017), Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 231 дэх тал. <http://kremlin.ru/acts/bank/15164> Сүүлд үзсэн огноо: 2018.12.24.

	нийгмийн баталгаа эдлүүлэх тухай" Ерөнхийлөгчийн зарлиг	– Засгийн газрын тэргүүн, түүний орлогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд тогтоосонтой адил нөхцөл, журмаар нийгэм-ахуй, эмнэлэг, амралт, сувиллын үйлчилгээний аливаа хөнгөлөлтийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд адил эдлүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч тэтгэвэрт гараад нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүн тус бүрт өндөр насны тэтгэврийн хуулийн дагуу тогтоосон суурь тэтгэврийн хэмжээг 165 хувиар нэмэгдүүлсэн хэмжээтэй тэнцэх мөнгөн тэтгэлгийг сар бүр олгохын зэрэгцээ гэр бүлд нь шүүхийн шүүгчийн 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлгийг 1 удаа олгох, бэлбэсэн эхнэр, нөхөр болон насанд хүрээгүй хүүхэд нь орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийн хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдлэх эрхтэй байх зэрэг олон төрлийн нийгэм, эдийн засгийн баталгааг эдлүүлэхээр тусгасан байна.
--	---	--

Гадаад улс, орнуудад Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг хуульд нарийвчлан тусгаж өгсөн байхад Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийг ерөнхий байдлаар тусгаж өгсөн нь цэцийн хараат бус байдалд эргээд нөлөөлөх сөрөг дагавар үүсгэх боломжтой. Иймд бусад улсын жишгийг харьцуулан цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгааг нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай.

3.3.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай зохицуулсан тус 5-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт сөрөг үр дагавар гарч байгаа эсэх, хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзсэн байна вэ гэдгийг авч үзнэ. Тодруулбал, Цэцийн гишүүний бүрэн эрхийн байдал практикт хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, эерэг болон сөрөг үр дагавар, хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдлыг судална.

Цэцийн тухай хуулийн 5.5-т цэцийн гишүүн төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн тохиолдолд бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох буюу төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 насанд бүрэн эрхийг хугацаа дуусгавар болгохоор зохицуулсан байна. Цэцийн тэтгэвэрт гарах насыг ажлын ачаалал, өндөр хариуцлага болон хэт өндөр настай байх нь сөрөг үр дагавартай гэж үзэн жинхэнэ албан хаагчийн тэтгэвэрт гарах насыг тогтоосон байна. Гэвч Цэцийн гишүүнийг улираан сонгох хязгаарлалтыг зохицуулаагүй улмаас зарим гишүүд удаа дараа дахин сонгогдож байсан байна.

Тухайлбал Цэцийн гишүүн Ж.Одбаяр 2016 онд цэцийн гишүүнээр томилогдож ажиллаж эхэлсэн бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон ч идэвхтэй ажиллаж байна. Мөн Цэцийн дарга Н.Чинбат 2017 оны 6 дугаар сарын 9-нд Цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж эхэлсэн боловч бүрэн эрхийн хугацаа 5 сарын өмнө

дуусгавар болсон байна. Цэцийн дарга 67 настай бөгөөд тэтгэвэрт гарах нас нь хэтэрсэн байна.

Үүнээс дүгнэхэд Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйл практикт хэрэгжиж байгааг харахад эргэлзээтэй байна.

3.4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ/ МУҮХЦтХ-ийн 6-р зүйл/

6 дугаар зүйл. Цэцийн дарга, түүний эрх хэмжээ

- 1.Цэцийн даргаар сонгох хүний нэрийг Цэцийн гишүүд дотроосоо дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, саналыг нууцаар хурааж нийт гишүүний олонхийн санал авсан хүнийг сонгоно.
2. Цэцийн даргад гурав буюу түүнээс дээш нэр дэвшиж, анхны санал хураалтаар хэн нь ч нийт гишүүний олонхийн санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хурааж нийт гишүүний олонхийн санал авсан хүнийг Цэцийн даргаар сонгоно.
3. Цэцийн даргын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.
4. Цэцийн дарга Цэцээс үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах, гишүүдийн төлөөлөлтийн байдлыг тэнцүүлэн Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилох, гишүүдийн ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлийн хяналт тавих, Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцана.
5. Цэцийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тогтоол, тушаал гаргана.
- 6.Цэцийн даргын түр эзгүйд Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн удаан ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмад гишүүн Цэцийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

3.4.1. Зорилгод хүрсэн түвшин

МУҮндХ-ийн 65-р зүйлийн 3-т “Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж, мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2.1-т “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол улсын Үндсэн хуульд нийцэх хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж тусгасан байдаг. Иймд цэцийн дарга бүрэн эрхийн хугацаандаа бие даасан, хараат бусаар ажиллаж чадаж буй эсэх, түүний баталгааг тус хуулиар хангаж чадаж байгаа эсэхийг судална.

Цэцийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргах талаар хуульд зохицуулж өгсөн байдаг. Гэтэл зарим тохиолдолд цэцийн даргын тушаал цэцийн гишүүний хараат бус байдлыг хөндөж байна гэж зарим судлаачид үзсэн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар их хэмжээний хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй улмаас зөрчил үүсэж Цэцийн дарга Ж.Амарсанаа “хөрөнгө, орлогын мэдүүлгээ бичихдээ хайхрамгүй хандсан, хөрөнгө орлогын өөрчлөлтөө бүрэн гүйцэт мэдүүлээгүй алдаа дутагдал^{21,22}” гарсан гэдгийг тогтоож түүнд албан тушаалын цалин бууруулах шийтгэл оногдуулах тушаал гаргасан байна. Гэвч Цэцийн дарга цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах бүрэн эрх хуулиар зохицуулагдаагүй байна.

Хэрэв Цэцийн дарга бусад цэцийн гишүүддээ хариуцлага тооцох үйлдэл гаргавал цэцийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй байна. Үндсэн хуулийн 64.2-ын “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд

²¹ Доктор О.Мөнхсайхан, Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ, Хууль дээдлэх ёс, 2014, Цуврал 2(48)

²² “Д.Сугар ба Цалингийн 30 Хувь”, news.mn

захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна” гэж тусгаж өгсөн. Иймд дээрх зүйл заалт тус хуулийн зорилтод нийцэхгүй байна гэдгийг харж болно.

Мөн МУҮндХ-ийн 65.3-т “3.Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхын саналаар сонгоно. Түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж зааж өгсөн. Харин Хуульч Н. Отгончимэгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”-нд гадаадын зарим орнуудад цэцийн даргыг өөрсдөө биш өөр хуулийн этгээдээр сонгуулдаг байна.

Тухайлбал, Австрийн Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг Холбооны Засгийн газрын санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилно. Оросын Үндсэн хуулийн шүүхийн дарга болон хоёр орлогч даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилдог²³ байна. Доорх хүснэгтээс харахад цэцийн даргыг тусдаа “хөндлөнгийн этгээд буюу улсын Ерөнхийлөгч, парламент нь томилдог байна.

Хүснэгт 2. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн дарга/ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, томилох²⁴

Улс	Дарга, орлогч	Санал болгох буюу нэр дэвшүүлэх этгээд	Томилох этгээд
ХБНГУ	-Ерөнхийлөгч, -Дэд ерөнхийлөгчтэй. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулинд заасан.	Нэр дэвшүүлэх ажлыг Бундестагийн дэргэд байгуулагдах, түүний 12 гишүүдээс бүрдэх Сонгох хороо хийнэ.	Ерөнхийлөгчийг эхний удаад Бундестаг, Дэд ерөнхийлөгчийг эхний удаад Бундестрат сонгоно. Дараагийн удаад Бундестаг, Бундестрат эрхээ солин хэрэгжүүлдэг
Австри	-Ерөнхийлөгч, -Дэд ерөнхийлөгчтэй. Үндсэн хуулинд заасан.	Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг Холбооны Засгийн газар санал болгоно.	Ерөнхийлөгч томилно.
ОХУ	-Дарга, -2 Орлогч даргатай	ОХУ-ын Ерөнхийлөгч санал болгоно	Холбооны зөвлөл 6 жилийн хугацаагаар томилно. Дахин томилж болно.
Солонгос	Ерөнхийлөгч	Томилох зөвшөөрлийг Үндэсний ассамблей өгнө	Ерөнхийлөгч томилно.
Латви	Ерөнхийлөгч	Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид дундаас Ерөнхийлөгч санал болгоно	Сеймас (парламент) томилно.

3.4.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн дарга, түүний эрх хэмжээний талаар зохицуулсан тус 6-р зүйл хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгааг авч үзэх буюу Цэцийн дарга эрх

²³ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 23-р зүйл.

²⁴ Н. Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”

хэмжээг хуулиар оновчтой зохицуулсан эсэх, практикт ямар үр дагаврыг гарч байгаа талаар судалж үнэлэлт өгнө.

Үндсэн хуулийн 6.3-т “Цэцийн дарга бүрэн эрхийн хугацаа хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэж зохицуулсан байна. Цэцийн дарга Н.Чинбат 2019 онд даргаар сонгогдож ажиллаж эхлээд үргэлжлүүлэн ажиллаж байна. Цэцийн даргын бүрэн эрхийн хугацаа 2022 онд дууссан ч хуулийн дагуу нэг удаа улируулан сонгоход бүрэн эрхийн хугацаа асуудалгүй байна. Гэхдээ тус хуулийн 5.5-т “төрийн албан хаах насны дээд хязгаарт хүрснээр цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно” гэж заасан нь Цэцийн дарга тэтгэврийн насанд хүрсэн ч ажлаа үргэлжлүүлэн ажиллаж байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын эрх хэмжээгээ хэтрүүлэн хэрэглэж цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулсан тушаал гаргасан талаар зарим судлаачид цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан гэж үзэж байна. Мөн ҮХЦТХ-д насны дээд хязгаарт хүрснээр цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно гэж хуульчилсан ч зарим тохиолдолд тэтгэврийн нас хүрсэн ч ажлаа үргэлжлүүлэн хийх тохиолдолд гарч байгаа нь тухайн хууль практикт хэрэгжихгүй байгааг илтгэж байна. Иймд цэцийн даргын эрх хэмжээг бусад цэцийн гишүүний хараат бус байдалд халдахгүй байхаар нарийвчлан тодорхойлж өгөх, гадаад орнуудын жишигт цэцийн даргыг цэцийн гишүүний дундаас бус өөр хуулийн этгээдээр сонгуулдаг байна.

3.5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл /МУҮХЦТХ-ийн 7-р зүйл/

7 дугаар зүйл. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл

1. Цэц нь ажлын албатай байна. Түүний орон тоог Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан Цэцийн ажлын албаны дарга тогтооно.
2. Цэц тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн нүүртэй байна. Цэцийн тамгыг Цэцийн дарга барина.
3. Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож батална.
4. Цэцийн гишүүн өмсгөлтэй байна. Цэцийн гишүүний өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурал батална.

3.5.1. Зорилгод хүрсэн түвшин

Энэ хэсэгт Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийн тухай зохицуулалт нь МУҮндХ-ийн 64-р зүйлийн 1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд нийцсэн эсэх буюу Цэц энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг тус хуулиар хангалттай зохицуулж чадсан эсэх, тийнхүү зохицуулахдаа МУҮндХ-ийн тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

Монгол Улсын Үндсэн хуульд “Үндсэн хуулийн шүүхийн бие даасан, хараат бус байдлыг нэгд, төсөв санхүүгийн бие даасан байдал, хоёрт, зохион байгуулалтын асуудлаа шийдвэрлэх эрх, гуравт, боловсон хүчний асуудлаа бие даан шийдвэрлэх

тухайд тусгаж зохицуулсан байна²⁵.” Мөн Монгол Улсын “Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг хангах, Цэц, түүний гишүүдийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, судалгаа, шинжилгээ, мэдээлэл, лавлагааны асуудлаар дэмжлэг үзүүлэх, хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй”²⁶ байна гэж Үндсэн хуулийн цэцийн цахим хуудсан дээр тодорхойлж өгсөн боловч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйл дээр Үндсэн хууль цэц ажлын албатай байна гэхээс өөр эрх зүйн байдлыг тодорхой тусгаж зохицуулаагүй байна.

Шигтгээ 1²⁷

Үндсэн хуулийн цэцийн ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд тодорхой бүтэц, зохион байгуулалтын нэгжтэй 40 орчим хүнтэй ажиллаж байна. Цэц нь эдүгээ үйл ажиллагаа явуулах нөхцөл хангасан өөрийн байртай бөгөөд түүнийг Үндсэн хуулийн цэцийн ордон гэнэ. Үндсэн хуулийн шүүхийн байр нь төрийн тусгай хамгаалалтад байна. Үндсэн хуулийн цэц өөрийн байртай байх нь нэг талаар Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрх, түүнчлэн Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, түүнийг сахин хамгаалах чиг үүргээ тасралтгүй, шуурхай хэрэгжүүлэх, түүнчлэн иргэний өргөдөл, мэдээлэл болон эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийг үндэслэн Үндсэн хууль зөрчсөн гэх маргааныг ямар нэгэн саад бэрхшээлгүй шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Үүнээс үзэхэд цэцийн тамгын газар нь Цэцийн үйл ажиллагааг явуулахад маш чухал оролцоотой нь харагдаж байна. Иймд хуулийн зорилго болох цэцийн үйл ажиллагааны зарчим, бүрэлдэхүүн болон зохион байгуулалтыг тодорхой хуульд зохицуулж өгөөгүй нь хуулийн зорилгодоо хүрээгүй байгааг илтгэж байна.

Гадаадын орнуудад цэцийн ажлын албаны талаар хэрхэн тусгасан байдлыг авч авч үзье.

Хүснэгт 3. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба²⁸

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн шүүхийн захиргаа
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нь шүүхийн захиргааны талаар зохицуулалт тусгагдаагүй. Харин Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүгд хурлаар Шүүхийн процедурын журмыг баталж, түүнд шүүхийн захиргааны талаарх үндсэн зохицуулалтыг оруулжээ. Шүүхийн захиргааны Захирал болон дарга нь танхимын даргалагч шүүгч нарт танхимын үйл ажиллагааг явуулахад туслалцаа үзүүлнэ. Шүүхийн захиргааг Үндсэн хуулийн шүүхийн

²⁵ Н. Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”

²⁶ https://www.conscourt.gov.mn/?page_id=625, 2023.11.14

²⁷ ХЗҮХ, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан.2018

²⁸ Мөн, тэнд

		Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс Үндсэн хуулийн шүүхийн Захирал удирддаг байна²⁹. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн захиргаа нь Шүүхийн захиргаа, Ерөнхий захиргаа, Мэдээллийн технологи, баримтжуулалтын газар, Протоколын газар, Номын сангаас бүрдэнэ. I.Шүүхийн захиргаа/Judicial administration II.Ерөнхий захиргаа/General Administration III.Мэдээллийн технологийн баримтжуулалтын газар/ IV.Протоколын газар/Protocol
Австри	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн захиргааны талаар тусгаагүй.	Харин тухайн шүүхийн цахим хуудсанд шүүхийн Захиргаа нь дараах бүтэцтэй³⁰ гэж тэмдэглэжээ: 1. Шүүхийн асуудал, чанар ба мэдлэгийн менежментийн газар 2. Боловсон хүчний менежмент, хөгжлийн газар 3. Санхүү, эдийн засгийн асуудлын газар 4. Олон улсын харилцаа, протоколын газар 5. Мэдээлэл, харилцаа холбооны технологи газар 6. Номын сан, харилцаа холбооны газар 7. Зохион байгуулалт, төслийн менежмент, архивын газар 8. Хэвлэлийн төлөөлөгч, хэвлэл мэдээллийн бусад асуудал эрхэлсэн газар Шүүхийн захиргааны Ерөнхий захирал удирдаж ажилтнуудын ажлын гүйцэтгэл, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавина.
ОХУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 111-р зүйлд шүүхийн захиргаа буюу ажлын албаны талаар тусгажээ.	Үндсэн хуулийн шүүхийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн аппарат/захиргаа-ын ерөнхий удирдлагыг хэрэгжүүлж, аппаратын удирдлага болон Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, Тамгын газрын журам болон аппаратын бүтцийг батлуулах асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд өргөн мэдүүлдэг. I.Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газар Тамгын газар нь дараах 11 нэгжээс бүрддэг: 1.Нийтийн эрх зүйн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 2.Хувийн эрх зүйн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг эрхэлсэн газар 4.Эрүүгийн хууль тогтоомжийн Үндсэн хуулийн үндсийг эрхэлсэн газар 5.Редакц-бүтээлийн газар 6.Олон улсын харилцаа болон үндсэн хуулийн

²⁹Rules of Procedure of the Federal Constitutional Court/ Германы Үндсэн хуулийн шүүхийн процедурын журмын 12-р болон 15-р зүйл. Эх сурвалж: https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_BVerfG.html#download=1

³⁰ Эх сурвалж: <https://www.vfgh.gv.at/verfassungsgerichtshof/organisation/Management.en.html>

		хяналтын үйл ажиллагааг таниулах ажлыг эрхэлсэн газар 7.Эрх зүйн мэдээлэл эрхэлсэн газар 8.Шүүх хуралдааны зохион байгуулалт эрхэлсэн нэгж 9.Хэвлэлийн мэдээллийн нэгж 10.Иргэдийг хүлээн авах, захидал харилцаа эрхэлсэн нэгж 11.Хэрэг шийдвэрлэх ажиллагааг хангах нэгж II.Төрийн алба ба хүний нөөцийн удирдлагын газар Дараах асуудлыг эрхэлдэг: - Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах хүний нөөцийн баримт бичгийг бэлтгэх, ажилтнуудыг томилох, чөлөөлөх, шилжүүлэх бэлтгэл хангах, ажилчдыг магадлан итгэмжлэх шалгалт авах, ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх асуудал, III.Санхүүгийн удирдлагын газар Дараах асуудлыг эрхэлдэг: - Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, бүтцийн онцлогийг харгалзан, санхүүгийн тогтвортой байдлыг ханган нягтлан бодох бүртгэлийг хөтлөх. IV.Хэрэг эрхлэх удирдлагын газар Дараах асуудлыг эрхэлдэг: - ханган нийлүүлэлт төлөвлөх, зохион байгуулах, материал-техникийн эх үүсвэрээр хангах, кабелийн сүлжээ, холбооны системийн ашиглалтанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, арга хэмжээ, албан ёсны уулзалтыг зохион байгуулах, төлөвлөх, шүүгч нарын нийгэм ахуйн хангамжийг зохион байгуулах. V.Үндсэн хуулийн шүүхийн Москва дахь төлөөлөгчийн газар - Үндсэн хуулийн шүүхэд иргэд хандах нөхцөл бүрдүүлэх, байнгын харилцаа холбоог хангах чиг үүрэгтэй.
Солонгос улс	Үндсэн хуулийн шүүхийн захиргааны талаар Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 17-р зүйлд тусгажээ	Шүүхийн захиргаа нь Үндсэн хуулийн шүүхийн захиргааны үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй. Шүүхийн захиргааг Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч удирдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн удирдлага дор шүүхийн захиргааны албан хаагчдыг удирдаж, зохион байгуулдаг. Ингэхдээ Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний ассамблей буюу парламент, Төрийн зөвлөлийн хуралд оролцож Үндсэн хуулийн шүүхийн захиргааны талаар мэдээлэл өгөх бүрэн эрхийг хуулиараа олгосон байдаг. Хэрэв захиран зарцуулах үйл ажиллагаатай нь холбогдуулах Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч захиргааны маргаан үүсгэвэл Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцагч байна гэж хуульчилжээ.

		Харин орлогч дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргад туслах, түүний эзгүйд түүний өмнөөс бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Шүүхийн захиргаа нь ажлын алба, товчоо, хэлтэстэй байна. Тэдгээрийн зохион байгуулалт, ажилтны тоо зэрэг асуудлыг Үндсэн хуулийн шүүх журмаараа шийдвэрлэхээр заасан байна. Шүүхийн захиргааны удирдлага болон албан хаагчид нь төрийн албан хаагчийн хэддүгээр зэрэгтэй алба хаагчдаас томилогдож болохыг Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульдаа тусгасан байна. Шүүхийн захиргаанд ажиллах албан хаагчдыг Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч томилж, чөлөөлдөг. Гэхдээ төрийн албан хаагчийн III зэргээс дээш зэрэгтэй албан хаагчийг томилж, чөлөөлөх асуудлыг Шүүгчдийн зөвлөлийн оролцоотой буюу тэдний саналд үндэслэн шийдвэрлэхээр хуульдаа заажээ. Солонгосын зохицуулалтын онцлог нь Үндсэн хуулийн шүүхийн судалгааны асуудалд ихээхэн ач холбогдол өгч "Үндсэн хуулийн судалгааны ажилтнууд" гэсэн тусдаа зүйлд тусгажээ. Үндсэн хуулийн шүүхэд судалгааны ажилтнууд ажиллах ба тэдгээрийн тоог Үндсэн хуулийн шүүхийн журмаар зохицуулдаг. Судалгааны ажилтнууд Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн шийдвэрээр хэргийг шалгах, шийдвэрлэхтэй холбоотой судалгаа, шалгалтын ажилд оролцох чиг үүрэгтэй. Судалгааны ажилтнуудыг Хууль зүйн зөвлөлийн шийдвэрт үндэслэн Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч 10 жилийн хугацаагаар томилох ба дахин томилж болно. Тэд 60 нас хүрмэгц өндөр насны тэтгэвэрт гарах зохицуулалттай. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнаар анх томилогдох тохиолдолд эхний 3 жилд судалгааны туслах ажилтан гэсэн статустайгаар ажилладаг байна. Үүний зэрэгцээ Солонгос улсын бас нэг онцлог нь хэрэг маргааныг шалгах, шийдвэрлэхэд мэргэжлийн шалгалт, судалгаа хийх шаардлагатай тохиолдолд Үндсэн хуулийн шүүх тусгай төлөөлөгчийг/commissioner татан оролцуулж болдог байна. Ийм тусгай төлөөлөгчийг 3 хүртэл жилийн хугацаагаар томилж ажиллуулдаг. Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнуудаас гадна тус шүүхийн дэргэд 40 хүртэл тооны ажилтнаас бүрдэх Үндсэн хуулийн судалгааны хүрээлэн ажиллана гэдгийг хуульдаа мөн тусгажээ. Тус хүрээлэн нь Үндсэн хуулийн судалгаа, Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа судалгаа, Үндсэн хуулийн шүүхийн судалгааны ажилтнуудын болон Шүүхийн захиргааны газрын албан хаагчдын сургалтыг хариуцан
--	--	---

		эрхэлдэг ба шүүхийн Захиргааны газарт харьяалагддаггүй. Үндсэн хуулийн судалгааны хүрээлэнгийн ажилтнуудыг Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч бие даасан томилох бүрэн эрхтэй.
Латви	Үндсэн хуулийн шүүхийн ажлын албаны талаар хуулинд нь ямар нэг заалт тусгагдаагүй байх бөгөөд ажлын албаны үндсэн бүтцийг Үндсэн хуулийн шүүхийн журамд тусгасан байна ³¹	Үндсэн хуулийн шүүх ажлын албаныхаа бүтэц, журам, зохион байгуулалтыг батална. Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба дараах үндсэн бүтэцтэй байна. 1. Канцлер буюу Ерөнхий нарийн бичгийн дарга; 2. Ерөнхийлөгчийн зөвлөх, Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхий нарийн бичгийн даргад шууд захирагддаг төрийн бусад албан хаагчид; 3. шүүхийн туслахууд; 4. Хууль зүйн судалгааны хэлтэс; 5. Захиргаа, протоколын хэлтэс; 6. Хүний нөөцийн хэлтэс.

Гадаад орнуудын жишгийг харахад Үндсэн хуулийн шүүхийн ажлын албаны эрх зүйн байдлыг хуулиар маш нарийн зохицуулж өгсөн байна. Солонгос улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн захиргаа, зохион байгуулалт, ажилчдын эрх зүйн байдлын талаар хуулийн зохицуулалтыг тодорхой болгож өгсөн байна.

Иймд Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зохицуулалтыг журмаар эсвэл хуульд нэмэлт зүйл заалтаар тодорхой зохицуулж өгөх шаардлагатай харагдаж байна.

3.5.2. Практикт нийцэж байгаа байдал

Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон тус зүйлийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална.

Цэцийн ажлын алба цэцийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад чухал алба гүйцэтгэдэг боловч эрх зүйн байдлыг мөн тодорхойгүй зохицуулж өгсөн байна. Харин бусад гадаад орнуудад цэцийн ажлын албын тодорхой зохицуулж өгснөөр хүний нөөцийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх үндэс суурийг хангасан байна. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зохицуулалтыг журмаар эсвэл хуульд нэмэлт зүйл заалтаар тодорхой зохицуулж өгөх шаардлагатай харагдаж байна

Цэцийн бие даасан байдлыг хангах асуудлын нэг болох цэцийн эдийн засгийн баталгааг хангах, тэр дундаа цэцийн гишүүдийн цалин хангамж, нийгмийн баталгааг хангаж өгөх нь чухал байр суурийг эзэлдэг. Гэвч зарим судлаачид цэцийн төсөв,

³¹ The Rules of the Constitutional Court/Үндсэн хуулийн шүүхийн журам, 46-р зүйл. Эх сурвалж: <https://www.lrkt.lt/en/administrative-information/rules-and-regulations/the-rules-of-the-constitutional-court/1296>

цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Улсын их хурлаар батлуулахад төсвийг танах асуудал гарах, мөн хараат байдлын талаар болгоомжилсон байна. Иймд цэц болон цэцийн гишүүд албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангахад төр анхаарах шаардлагатай. Цэц болон цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгааг баталгаажуулсан зүйл заалтуудыг нэмж хуульчлах шаардлагатай.

3.5.3. Үндсэн хуулийн цэцийн эдийн засгийн бие даасан байдал

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал тэр дундаа цэцийн эдийн засгийн баталгаанд шүүх үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүрэлцэхүйц хэмжээний төсөвтэй байх, цэц эдийн засгийн хувьд хэнээс ч хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх үндсийг хамааруулна.

Гэвч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн судалгаанд эрдэмтэд, судлаачид “Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүний цалингийн хэмжээний хувьд зарим талаар Улсын Их Хурлаас хараат байгаа байдал ажиглагдаж байна³²” болон “Цэцийн төсөв нь санхүүгийн хувьд бие даасан байж чиг үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдах ёстой. Улсын Их Хурал төсөв батлахдаа Цэцийн төсвийг танах, хасах явдал гаргадаг³³” зэрэг асуудал тулгарч байгааг судалгаанд онцолсон байна. Үүнээс харахад цэцийн бие даасан байдлын гол шалгуур болох эдийн засгийн баталгаа буюу төсөв, санхүүгийн байдал Улсын Их Хурлаас хамааралтай харагдаж байна.

Харин гадаад орнуудад дараах байдлаар Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү хуульд тусгаж өгсөн байна.

Хүснэгт 4. Гадаад улсуудын зохицуулалт: Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү³⁴

Улс орнууд	Хуулийн нэр	Үндсэн хуулийн шүүхийн төсөв, санхүү
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 1-р зүйлийн 1-д “Холбооны Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн бусад байгууллагаас бие даасан, хараат бус байна.” гэж заажээ. Харин Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүхийн төсөв, санхүүтэй холбоотой тухайлсан зохицуулалт тусгагдаагүй байна.
ОХУ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүх холбооны улсын төсвөөс санхүүжиж, санхүүжилт нь үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Жил бүрийн төсөвт Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах эх үүсвэрийг бие даасан зүйл болгон тусгах бөгөөд үүнийгээ Үндсэн хуулийн шүүх бие даан зарцуулна.

³² ХЗҮХ-ийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт” хийсэн үнэлгээний тайлан, 2018

³³ Д.Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”

³⁴ Н. Отгончимэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа”

		Мөн төсвийг өмнөх жилийнхээс буруулж болохгүй заалттай. Үндсэн хуулийн шүүх нь мэдээлэл, хүний нөөций асуудлаа бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэйг мөн хуульчилсан байна. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны эрх зүй, зохион байгуулалт, санхүү, мэдээлэл, материал-техник, хүний нөөцийн зэрэг нөхцөлийг хязгаарлахыг хоригложээ.
Солонгос	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	“Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт бие даан тусгана”³⁵ гэсний зэрэгцээ нөөц хөрөнгийг энэхүү зардалд багтаасан байхаар мөн хуульд заасан байна. Энэхүү төсөв боловсруулах, зардал, нөөц хөрөнгийн асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлөөр шийдвэрлэхээр заажээ³⁶.
Латви	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль	Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал нь бие даасан төсөвтэй байх, зохион байгуулалт, материал-техникийн асуудлаа өөрөө бие даасан шийдвэрлэхэд оршиж байна. Үндсэн хуулийн шүүхийн эрх чөлөө, бие даасан байдал нь хуульд заасан санхүү, материал-техник, зохион байгуулалтын баталгаагаар хангагдана. Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн хяналтын чиг үүргээ бие даан, зохих байдлаар хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжинэ. Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллоо өөрөө батлах бөгөөд хуваарилагдсан эх үүсвэрийг бие даан зарцуулна. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх нь мэдээллийн болон зохион байгуулалтын ханган нийлүүлэлтийг чөлөөтэй, бие дааж хэрэгжүүлнэ. Латви улсад Үндсэн хуулийн шүүх нь зардлын тооцооллыг өөрөө батлах бүрэн эрх олгогдсон нь онцлог байна.

Үүнээс үзэхэд гадаадын орнуудад Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал, эдийн засгийн баталгаа хуулиар баталгаажуулж өгсөн нь шүүгчийг гадны нөлөөнөөс хамгаалах боломжийг олгож байна.

Цэцийн эдийн засгийн баталгаа хангагдах эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжихгүй байгаа учир Шүүхийн тухай хуулийн гол баталгаа буюу 5.6. “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад

³⁵ Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 11-р зүйл.

³⁶ Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 16-р зүйлийн 2.

тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” заалтыг нэмж эдийн засгийн баталгаа гаргаж өгөх хэрэгтэй.

Шүүхийн бие даасан байдлыг хангах гэдэг нь хоёр үндсэн утгыг илэрхийлдэг. Үүнд нэг талаас шүүх эрх мэдлийг төрийн бусад эрх мэдэл болох хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс харьцангуй бие даалгах³⁷ нөгөө талаас шүүх эрх мэдлийг шүүх бүр бие даан хэрэгжүүлэх юм³⁸. Үүний ойлгомжтойгоор илэрхийлбэл шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад шүүхийг гаднаас буюу төрийн эрх мэдлийн бусад субъектээс хамгаалах нөгөө талаар шүүхийг шүүхийн өөрийн удирдлага, захиргаанаас хамгаалах гэж тайлбарлаж болно³⁹.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрх хэмжээний гол заалтууд болох ҮХЦХ-ийн 5 дугаар зүйл “Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа” хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь эргээд цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байна. Бусад гадаад орнуудын жишгийг харахад цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгаа, эрх зүйн байдлыг тусгайлан тодорхой зохицуулж өгсөн нь хараат бус байдлыг бэхжүүлж өгсөн байна. Иймд цэцийн хараат бус байдлыг хангахын тулд гадаад улсуудын жишгээс судлан цэцийн гишүүний бүрэн эрхийн эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай байна.

³⁷ Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл /“Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, УБ, 2001 он/, 56 хуу.

³⁸ Г.Совд “Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудал”, Монголын төр, эрх зүй, Дугаар 02/УБ, 1997/1.

³⁹ ХЗҮХ “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, “Шүүхийн шинэтгэлийн эрхийн хэрэгжилт, эрх зүй асуудал”, 72 хуу.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Цэцийн гишүүний томилгооны тухай МУҮХЦтХ-ийн 3-р зүйлд нь нэн тодорхойгүй буюу бүрэн гүйцэт зохицуулаагүйгээс Цэцийн гишүүнийг томилох процедур бүхэлдээ тодорхой бус явагдаж, нэр дэвшигч санал болгох эрх бүхий институтууд өөр өөрсдийнхөөрөө хөтлөн явуулж байна. Иймд дараах агуулгаар Цэцийн тухай хуулийг шинэчлэх хэрэгтэй гэж үзлээ. Үүнд:

- Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дуусгавар болсноос хойш тодорхой хугацааны дотор Ерөнхийлөгч, УИХ, УДШ-ээс тухайн гишүүний орны гишүүнийг санал болгох талаар нэг мөр хуульчлах;
- Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход нэр дэвшигчийн сонсгол хийх зохицуулалт нь нэр дэвшигчийг уг албан тушаалд тэнцэх эсэхийг шалгаж баталгаажуулахад чухал ач холбогдолтой тул нэр дэвшигчийн сонсгол хийх процессыг хуульчлах;
- Цэцийн гишүүнийг нэг удаа улируулан томилохыг зөвшөөрч бүрэн эрхийн хугацааг 12 жил байхаар зохицуулах.

2. Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг МУҮХЦтХ-ийн 4-р зүйлд хэт ерөнхий тодорхойлсноос практикт эрх зүйч бус хүн Цэцийн гишүүн болох жишиг тогтож, үүнээс үүдэж Цэц үндсэн хуулийн шүүх болохын хувьд мэргэшсэн байж чадахгүйд хүрч байна. Иймд Цэцийн тухай хууль органик хууль болохын хувьд тус хуульд МУҮндХ-ийн 65 дугаар зүйлийн 2-ыг дэлгэрүүлэн Цэцийн гишүүн эрх зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэшлийн шаардлагыг хангасан байхыг тухайлан зааж шинэчлэх шаардлагатай.

3. Цэцийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох, түдгэлзүүлэх тухай МУҮХЦтХ-ийн 5-р зүйлд хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь Цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байна. Иймд Цэцийн хараат бус байдлыг хангахын тулд Цэцийн гишүүний бүрэн эрхийг Цэцийн тухай хуульд нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай байна.

4. Цэцийн дарга, түүний эрх хэмжээний тухай зохицуулсан МУҮХЦтХ-ийн 6-р зүйл нь зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй байгаагаас практикт тэтгэврийн насанд хүрсэн ч Цэцийн гишүүний бүрэн эрхийг үргэлжлүүлэх, Цэцийн даргын эрх хэмжээгээ хэтрүүлэн хэрэглэж цэцийн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах зэргээр Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан тохиолдлууд гарсаар байна. Түүнчлэн Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах, хуралдааны бүрэлдэхүүнийг томилохтой холбогдох харилцааг Цэцийн даргын бүрэн эрхэд хамаарах байдлаар зохицуулсан нь Цэцийн хараат бус байдлын баталгааг алдагдуулж байна. Иймд Цэцийн тухай хуульд Цэцийн даргын эрх хэмжээг бусад цэцийн гишүүний хараат бус байдалд халдахгүй байхаар нарийвчлан тодорхойлж, Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах, хуралдааны бүрэлдэхүүнийг томилохтой холбогдох харилцааг шүүхийн нийтлэг жишгийн адилаар зохицуулах нь зүйтэй.

5. Цэцийн үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон МУҮХЦтХ-ийн 7-р зүйл нь зорилгод хүрэх түвшин хангалтгүй буюу Цэцийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлдэг ажлын албаны эрх зүйн байдлыг тодорхой заагаагүй, Цэцийн

эдийн засгийн баталгаа, тэр дундаа ажлын албаны алба хаагчид, Цэцийн гишүүдийн цалин хангамж, нийгмийн баталгаа хангагдаагүй байна. Иймд Цэцийн ажлын албаны бүтэц, чиг үүргийг тодорхойлсон зохицуулалтыг, Цэц болон цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгааг баталгаажуулсан зүйл заалтуудын хамтаар Цэцийн тухай хуульд тусгайлан заах шаардлагатай байна.

6. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү судалгааны үр дүнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992), <https://legalinfo.mn/mn/detail/367>
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=365>
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, (1997), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=19>
4. Нийтийн сонсголын тухай хууль, (2015), <https://legalinfo.mn/mn/detail/11225>

Гадаад хэлээр:

1. Rules of Procedure of the Federal Constitutional Court/ Германы Үндсэн хуулийн шүүхийн процедурын журам, https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_BVerfG.html#download=1
2. ОХУ-ын Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
3. Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
4. Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
5. Австри Улсын Үндсэн хууль, https://www.vfgh.gv.at/downloads/VfGH_Broschuere_eng_barrierefrei_Final.pdf

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Г.Совд "Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд", Монголын төр, эрх зүй, Дугаар 02, УБ, 1997.
2. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2000.
3. Б.Чимид "Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд", илтгэл /"Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол-практикийн бага хурал, УБ, 2001.
4. Ч.Энхбаатар, "Үндсэн хуулийн эрх зүй", 2007.
5. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008.
6. ХЗДХЯ, Дэлхийн банкны "Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл", "Үндсэн хуулийн процессын эрх зүй" оюутны гарын авлага, (УБ, 2011).
7. О.Мөнхсайхан, "Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ", Эрх зүй 48, Дугаар 4 (2014).
8. Арне Мавичи, Үндсэн хуулийн хяналт, 2014.
9. О.Мөнхсайхан, "Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхой боломж", "Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: одоо ба ирээдүй" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2015.
10. О.Мөнхсайхан, "Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь," Эрх зүй 36, Дугаар 4 (2016).
11. Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, МУИС пресс, 2016.
12. П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа, УБ, 2017.

13. Д. Наранчимэг “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим”, Н.Жанцан нар, “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт, УБ, 2017.
14. Н.Номинчимэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд гадаад орнуудын туршлага судлах харьцуулсан судалгаа, 2019.
15. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, УБ, 2021.
16. Н.Лүндэндорж, “Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар”, УБ, 2023.
17. ХЗҮХ, Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, 2023.
18. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, хоёр дахь хэвлэл, УБ 2021

Гадаад хэлээр:

1. 성낙인, 헌법학, 법문사, 2021.
2. Арне Мавчич, Үндсэн хуулийн хяналт (УБ, 2014), Мэргэн Их Монгол, 40-42 дахь тал. <https://www.us-rs.si/en/about-the-court/legal-basis/constitutional-court-act/> Сүүлд үзсэн огноо: 2018.12.24.
3. “Д.Сугар ба Цалингийн 30 Хувь”, news.mn
4. <https://www.courts.ca.gov/5367.htm>, 2023.11.16
5. <https://eguur.mn/415949/>, 2023.11.13

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Үндсэн хуулийн шүүгч нарын томилгоо ба УИХ-ын гишүүдийн хайнга байдал нотлогдов, 2018, <https://ikon.mn/opinion/1aqu>
2. С.Нарангэрэл, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаарх Академич С.Нарангэрэлийн бичмэл санал”, 2023, Холбоос:<https://ip.ac.mn/c/1013593?Content=37072>
3. Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт” Эрдэм шинжилгээний нийтлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>